



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар А/Д/77

Номгон

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд
ашиглах тоног төхөөрөмж авах ажилд эрх
шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2. а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж авахад шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг тус газарт эрх шилжүүлж, гүйцэтгүүлсүгэй.

2. Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу 08 дугаар сарын 05-ны дотор зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа (Д.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх 20,000,000 (Хорин сая) төгрөгийг аймгийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж авах ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хууль эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

601210101